



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Утас: 70522734	
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Утас: 70523020	
Ахлах аудитор: О.Нарангарав	Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гууламж, 3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103, Утас: (976) 7052 2734 Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn <u>2025.03.25 № 1-6/334</u> танай _____ -ны № _____ -т	ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.СОДМАГНАЙ ТАНАА
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Сумын татварын болон татварын бус нийт 787.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орон нутгийн төсөвт байгууллагуудад 767.6 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн санд 19.6 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.</p>	
<p>Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Тайлант онд 100 жилийн ой болсонтой холбогдуулан төсвийн харилцах дансаар дамжуулан хандив төвлөрүүлээгүй байна.</p>	
<p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
442502139	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	452,861.50	463,537.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	146,482.90	151,500.40
33	АВЛАГА	174,527.60	154,969.90
34	УРЬДЧИЛГАА	-	41,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,894.00	76,617.60
36	НӨӨЦИЙН БАРАА	56,956.90	39,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,698,855.40	3,196,964.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,698,855.40	3,196,964.50
39200	Биет хөрөнгө	2,625,650.60	3,124,050.40
39300	Биет бус хөрөнгө	73,204.90	72,914.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,151,716.90	3,660,502.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	64,660.00	28,865.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	64,660.00	28,865.00
41300	Өглөг	64,660.00	28,865.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,087,057.00	3,631,637.40
51	Засгийн газрын хувь оролцоо	3,087,057.00	3,631,637.40
51100	Засгийн газрын оруулсан капитал	946,290.20	946,290.20
51200	Хуримтлагдсан үр дүн	1,597,532.20	2,142,112.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	543,234.60	543,234.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,151,716.90	3,660,502.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,375,097.60	3,311,043.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	307,771.10	777,281.00
110	Орлогын албан татвар	200,105.10	666,250.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	200,105.10	666,250.20
113	Хөрөнгийн албан татвар	26,470.00	58,281.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	81,196.00	52,749.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	942,309.20	592,759.80
120	Нийтлэг татварын бус орлого	942,309.20	592,759.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,125,017.40	1,941,002.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,636,684.10	2,723,494.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,636,684.10	2,723,494.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,962,583.20	2,722,095.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	415,880.40	679,028.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,929.60	82,923.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,720.90	605,028.90
2104	Хангамж, бараа материалын зардал	640,705.90	640,868.00
2105	Нормативт зардал	3,614.50	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	723.30	13,558.70
2107	Томилолт, зочны зардал	13,332.50	7,055.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,143.20	449,808.90

Иххэт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	665,532.80	243,823.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	674,100.90	1,399.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	738,413.40	587,548.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	45,011.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	738,413.40	542,536.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	/мянган төгрөг/
			Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,348,643.50	-	2,348,643.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,348,643.50	-	2,348,643.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	738,413.40	-	738,413.40
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,087,057.00	-	3,087,057.00
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,087,057.00	-	3,087,057.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,043.50	-	2,043.50
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,089,100.50	-	3,089,100.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	542,536.90	-	542,536.90
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,631,637.40	-	3,631,637.40

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
		2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,495,106.80	2,784,910.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	307,771.10	777,281.00
110	Орлогын албан татвар	200,105.10	666,250.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	200,105.10	666,250.20
113	Хөрөнгийн албан татвар	26,470.00	58,281.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	81,196.00	52,749.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,557.40	11,584.40
1181	Газрын төлбөр	68,638.60	41,165.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,761.20	40,592.90
120	Нийтлэг татварын бус орлого	48,761.20	40,592.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,138,574.50	1,967,036.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,619,722.10	2,566,574.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,619,722.10	2,566,574.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,455,892.60	2,050,920.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	415,297.20	677,874.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,779.30	84,140.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,447.50	620,302.30
2104	Хангамж, бараа материалын зардал	29,723.60	61,269.30
2105	Нормативт зардал	600	600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,290.00	23,177.80
2107	Томилолт, зочны зардал	13,332.50	7,055.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	381,234.90	552,262.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	483,187.60	24,238.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,163,829.50	515,654.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-124,615.20	218,335.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,107.80	213,318.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,107.80	213,318.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,107.80	213,318.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-17,107.80	-213,318.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-141,723.00	5,017.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	288,206.00	146,482.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	146,482.90	151,500.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,230,606.60	2,048,726.71	181,879.89	91.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,230,606.60	2,048,726.71	181,879.89	91.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,622,539.40	1,543,735.02	78,804.38	95.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	717,043.90	677,874.52	39,169.38	94.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,469.30	84,140.21	13,329.09	86.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	636,537.60	620,302.27	16,235.33	97.45
2104	Хангамж, бараа материалын зардал	35,150.20	33,828.38	1,321.82	96.24
2105	Нормативт зардал	600.00	600.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,600.00	31,495.85	104.15	99.67
2107	Томилолт, зочны зардал	8,014.90	7,055.00	959.90	88.02
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,633.50	79,661.28	5,972.22	93.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,490.00	8,777.50	1,712.50	83.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	608,067.20	504,991.69	103,075.51	83.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	606,667.20	503,592.29	103,074.91	83.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400.00	1,399.40	0.60	99.96
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,230,606.60	2,058,542.00	172,064.60	92.29
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	546,455.60	464,829.60	81,626.00	85.06
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,622,939.40	1,563,042.51	59,896.89	96.31
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,211.60	30,669.89	30,541.71	50.10
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	131,022.15	131,022.15	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	140,837.44	140,837.44	#DIV/0!
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56	56	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/		
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	715,705.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	715,705.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	705,042.28
2104	Хангамж, бараа материалын зардал	27,440.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	672,601.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,662.97
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,662.97
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	715,705.25
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	715,705.25

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 төсвийн байгууллагад дүгнэлт гаргаж, 1 төсвийн байгууллага, тусгай сангийн 2 тайланд түүвэр аудит хийсэн.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын 1 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 857.4 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс 854.5 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	3	798.5			3	798.5	3	798.5				
Орон нутгийн хөгжлийн сан	3	56.0			3	56.0	3	56.0				
Дүн	6	854.5	0	-	6	854.5	6	854.5	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	1	2.9			1	2.9						
Дүн	1	2.9	0	-	1	2.9	0	-	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Орон нутгийн хөгжлийн сан	1	-							1	-	
Дүн	1	-	0	-	0	-	0	-	1	-	-